



АРХАНГАЙ АЙМГИЙН
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

АРХАНГАЙ АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГ НИЙГМИЙН БАЙДЛЫН ТУХАЙ ТАНИЛЦУУЛГА

2020/07




www.nso.mn www.arkhangai.nso.mn www.1212.mn



ЭРҮҮЛ МЭНД


Эмнэлгийн байгууллагууд 551 ор, амбулаторийн 99 их эмчтэйгээр хүн амд үйлчилж давхардсан тоогоор 199.4 мянган хүнд амбулаторийн үзлэг хийсний 69.9 мянгад нь урьдчилан сэргийлэх үзлэг хийж 11.9 мянган хүнийг эмнэлэгт хэвтүүлэн эмчилж гаргасан байна.

Вакцинжуулалтанд хамрагдвал зохих 0-2 насны хүүхдийн 98.2 хувийг бүрэн хамруулсны дотор Чулуут, Хайрхан, Хашаат, Хотонт, Төвшрүүлэх, Цахир сумд 100.0 хувь хамруулсан байна.



Оны эхний 7 сард 972 эх төрж, 979 хүүхэд амьд төрсөн нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 1.9 хувиар буюу 19 хүүхдээр бага байна. Хүн амын нас баралт 279 гарсан нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 48 тохиолдлоор буюу 14.7 хувиар бага байна. Мянган хүнд ноогдох төрөлт 10.3, нас баралт 3.0 ноогдож хүн амын ердийн цэвэр өсөлт 7.3 промил байна. Төрөхийн улмаас эндсэн эхийн эндэгдэл гараагүй, 1-5 насны хүүхдийн эндэгдэл 6, нялхсын буюу 0-1 насны хүүхдийн нас баралт 14 гарч мянган амьд төрөлтөд 14 ногдож байна.

Эндсэн хүүхдийн тоо, жил бүрийн эхний 7 сарын байдлаар



Аймгийн дүнгээр арван мянган хүн тутмаас 23 нь буюу 218 хүн халдварт өвчнөөр өвчилсөн байгаа бөгөөд Өлзийт(35), Булган (33), Эрдэнэбулган (28), Төвшрүүлэх (27), Цахир (25), Жаргалант (25), Батцэнгэл (22), Өндөр-Улаан (21), Ихтамир (20) сумдад аймгийн дунджаас дээгүүр бусад сумдад аймгийн дунджаас доогуур байна. Халдварт өвчнөөр өвчлөгсдийн 6.0 хувь нь салхин цэцгээр, 37.2 хувь нь бэлгийн замын халдварт өвчнөөр, 17.0 хувь нь сүрьеэгээр, 29.8 хувь нь цусан суулгаар, 10.0 хувь нь бусад халдварт өвчнөөр өвчилсөн байна. Халдварт өвчний гаралт өнгөрсөн оны мөн үеийнхээс 35.1 хувиар буюу 118 тохиолдлоор буурсан байна.




АЖИЛГҮЙДЭЛ, АЖЛЫН БАЙР

8 дугаар сарын 1-ний байдлаар хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгэлтэй ажил идэвхтэй хайж байгаа 980 ажилгүй хүн байгаагийн 51.3 хувь нь буюу 503 нь эмэгтэйчүүд байна. Хөдөлмөрийн насны 10.0 мянган хүн тутамд 151 ажилгүйчүүд ноогдож байгаа бөгөөд өнгөрсөн оны мөн үеийнхээс бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 26.8 хувиар буурсан байна. Бүртгэлтэй ажилгүйчүүдийн 99.2 хувь нь боловсролтой иргэд байгаагийн 159 нь дээд, 40 нь тусгай дунд болон мэргэжлийн

анхан шатны, 750 нь бүрэн болон бүрэн бус дунд, 23 нь бага боловсролтой хүмүүс байна.

7 дугаар сард ажилгүйчүүдийн бүртгэлд 228 хүн шинээр бүртгүүлж, 24 хүн ажил идэвхитэй хайхаа больсноос идэвхигүй болж 113 хүн ажилд зуучлуулан орсон байна.

Ажлын шинэ байранд ажилд орсон иргэний тоо



Оны эхний 7 сард аймгийн дүнгээр 543 ажлын байр шинээр бий болгосон байна. Шинэ ажлын байрыг сумдаар үзвэл Эрдэнэбулган сум 116, Эрдэнэмандал, Хангай, Хашаат, Цэнхэр, Хотонт, Өндөр-Улаан сумд 30-58 ажлын байрыг, Булган, Төвшрүүлэх, Өлзийт, Хайрхан, Ихтамир, Чулуут сумд 17-28 ажлын байрыг, Тариат, Цэцэрлэг, Жаргалант, Өгийнуур, Цахир, Батцэнгэл сумд 1-9 ажлын байрыг бий болгожээ.



НИЙГМИЙН ДААТГАЛ ХАЛАМЖ

Нийгмийн даатгалын сангийн орлого оны эхний 7 сард

40.2 тэрбум төг, зарлага 35.8 тэрбум төг болж өмнөх оныхоос орлого 6158.5 сая төг буюу 18.1 хувиар, зарлага 5801.8 сая төг буюу 17.2 хувиар өслөө.


Нийгмийн даатгалын сангийн орлого өмнөх оныхоос 6158.5 сая төгрөгөөр өсөхөд тэтгэврийн даатгалын сангийн орлого 18.8 хувиар, тэтгэмжийн даатгалын сан 20.9 хувиар, ажилгүйдлийн даатгалын сан 69.3 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Нийгмийн даатгалын сангийн зарлага өмнөх оныхоос 17.2 хувиар өсөхөд тэтгэврийн даатгалын сан 18.6 хувиар, тэтгэмжийн даатгалын сан 13.9 хувиар, эрүүл мэндийн даатгалын сан 4.3 хувиар, ажилгүйдлийн даатгалын сан 43.9 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна. Тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэрт 14.5 мянган хүнд 29.8 тэрбум төгрөг, тэтгэмжийн даатгалын сангаас бүх төрлийн тэтгэмжид 1471 хүнд 1356.9 сая төгрөгийг олгосон байна.

Оны эхний 7 сард нийгмийн халамжийн сан болон хүний хөгжил сангаас давхардсан тоогоор 50.1 мянган хүнд 8850.5 сая төгрөгийн тэтгэмж хөнгөлөлт тусламж, хишиг олгосон байна. Нийгмийн халамж үйлчилгээгээр олгосон нийт мөнгөний 63.9 хувь нь нийгмийн халамжийн сангаас олгосон халамжийн тэтгэвэр, нөхцөлт мөнгөн тэтгэмж, хөнгөлөлт, 36.1 хувийг улсын төсвөөс олгосон тэтгэмж тусламж эзэлж байна.

Нийгмийн халамжийн сангаас олгосон мөнгөний 59.7 хувийг халамжийн тэтгэврээр, 32.5 хувийг нөхцөлт мөнгөн тэтгэмжээр, 7.8 хувийг ахмад настан хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд олгосон болон хүнс тэжээлийн хөнгөлөлт тусламжид зарцуулж байна.


Нийгмийн халамжийн сангаас олгосон, тэтгэвэр, тэтгэмжийн бүтэц



ГЭМТ ХЭРЭГ

Аймгийн хэмжээгээр 179 хүн гэмт хэрэгт холбогдож 298 гэмт хэрэг гарсны дотор хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг 8, хүний амь бие эрүүл мэндийн эсрэг хэрэг 74, өмчлөх эрхийн эсрэг 168, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг 14, байгаль хамгаалах журмын эсрэг 21, бусад 13 хэрэг гарсан байна. Гэмт хэргийн улмаас 13 хүн нас барж, 85 хүн гэмтэж бэртэн улс болон иргэдэд 1129.3 сая төгрөгийн хохирол учирсан байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, гэмт хэрэгт холбогдогчийн тоо, жил бүрийн эхний 7 сарын байдлаар



Бүртгэгдсэн нийт хэргийн 7.7 хувийг бүлэглэж 17.4 хувийг согтуугаар үйлдсэн байгаа ба зөрчил гаргасан 52 хүнийг албадан саатуулж 239 хүнийг баривчилсан байна.

Гэмт хэргийн улмаас гэмтсэн, нас барсан хүний тоо, жил бүрийн эхний 7 сарын байдлаар



Өнгөрсөн оны мөн үетэй зэрэгцүүлэхэд бүртгэгдсэн гэмт хэргийн тоо 19.9 хувиар буюу 74 тохиолдлоор буурсны дотор хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг 50.0 хувиар буюу 8 тохиолдлоор буурч харин байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг 4.0 дахин буюу 16 тохиолдлоор өссөн байна.




ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО ЗАРЛАГА

Улсын төвлөрсөн төсвийн шилжүүлэг дэмжлэгийг оруулан тооцсоноор 2020 оны эхний 7 сард аймгийн төсөвт 13976.3 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 16084.5 сая төгрөгийн орлого оруулж төлөвлөгөөг 133.6 хувиар биелүүлсэн байна.

Улсын төсвийн шилжүүлэг дэмжлэгийг оруулахгүйгээр аймаг өөрөө 3965.3 сая төгрөгийн орлого бүрдүүлэхээс 6073.5 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлэн төлөвлөгөөг 153.2 хувиар

биелүүллээ. Төсвийн орлогын төлөвлөгөөг бүх сумд 121.3 хувиас 3 дахин давуулан биелүүлсэн байна.

Орон нутгийн төсвийн орлогын бүтэц, хувиар



Орлогыг нэр төрлөөр нь үзвэл бууны татвар, авто тээврийн болон өөрөө явагч тээврийн хэрэгслийн татвар, улсын тэмдэгтийн хураамж, газрын төлбөр, ойн нөөц ашигласны төлбөр, байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр, ус рашаан ашигласны төлбөр, төсөвт байгууллагын өөрийн орлогоос бусад нэрийн орлогуудыг 100.3 хувиас 6.0 дахин биелүүлсэн байна.

Аймгийн төсвийн орлогын 62.2 хувийг тусламжийн орлогоор, 25.5 хувийг орлогын албан татвараар, 1.1 хувийг өмчийн татвараар, 2.1 хувийг тусгай зориулалтын орлогоор /АТӨЯХэрэгслийн/, 3.0 хувийг бусад албан татвараар, 5.7 хувийг татварын бус орлогоор, 0.4 хувийг хөрөнгийн орлогоор бүрдүүлж байна.


Улсын төвлөрсөн төсөвт аж ахуй нэгжийн орлогын татвараар 191.9 сая төгрөг, нэмэгдсэн өртгийн албан татвараар 614.3 сая төгрөг, агаарын бохирдлын төлбөрөөр 30.2 сая төгрөг бүгд 841.6 сая төгрөгийг шилжүүлж даалгаврыг 129.8 хувиар давуулан биелүүллээ.



МӨНГӨ ЗЭЭЛ, ХАДГАЛАМЖ

Манай аймагт арилжааны 4 банкны салбар иргэд аж ахуй нэгж байгууллагуудад үйлчилгээ үзүүлж байна. Монгол банкны мэдээгээр арилжааны банкууд монгол банкнаас зузаатгалаар 14.9 тэрбум төгрөгийг авч 17.5 тэрбум төгрөгийг гүйлгээнээс эргүүлэн татсан байна.

Иргэдийн хадгаламжийн үлдэгдэл, олгосон зээлийн хэмжээ, жил бүрийн эхний 7 сарын байдлаар сая.төг



Оны эхний 7 сард банкууд 36.7 мянган иргэд, аж ахуй нэгжид 102.1 тэрбум төгрөгийн зээл олгосон байна. Өнгөрсөн оны мөн үеийнхтэй зэрэгцүүлэхэд иргэдийн хадгаламжийн үлдэгдэл 18.1 хувиар, олгосон зээлийн хэмжээ 44.7 хувиар өссөн байна. Харин анхаарал хандуулах зээлийн хэмжээ 23.8 хувиар буурч, чанаргүй зээлийн хэмжээ 38.8 хувиар нэмэгдсэн байна.



ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ

2020 оны 7 дугаар сард бараа үйлчилгээний үнэ тариф өмнөх сарынхаас 0.2 хувиар, өнгөрсөн оны мөн үеийнхээс 3.5

хувиар, 2019 оны 12-р сарынхаас 1.6 хувиар тус тус өссөн байна.

Өнгөрсөн 6 дугаар сартай зэрэгцүүлэхэд хэрэглээний сагсанд авсан 238 нэрийн бараа үйлчилгээний үнэ тарифын 10.5 хувийнх нь өсч, 3.4 хувийнх нь үнэ буурч 86.1 хувийнх нь үнэ тогтвортой байлаа. Тухайлбал өмнөх сарынхаас тараг, улаан лооль, үхрийн мах, байцаа, хонины ястай мах, өөхөн тос, сармисны үнэ 1.5-25.0 хувиар буурч харин ургамлын тос, тахианы мах, савласан сүү, зоогийн газрын хоолны үнэ, бензин А-80, дизелийн түлш, сонгино, цагаан тосон будагны үнэ 0.1– 74.0 хувиар нэмэгдсэн байна.

Өнгөрсөн жилийн эцэстэй зэрэгцүүлэхэд 6.7 хувийнх нь буюу 22 нэрийн бараа үйлчилгээний үнэ буурч, 42.4 хувийнх нь буюу 79 нэрийн бараа үйлчилгээний үнэ тариф өсч, 57.6 хувийнх нь үнэ тогтвортой байна.

Харин өнгөрсөн оны мөн үеийнхээс шатахуун, гэрийн гадуур бүрээс, алим, сурагчийн дөрвөлжин дэвтэр, эдийн саван, шүдэнз зэргийн 26 нэр төрлийн бараа бүтээгдэхүүний үнэ 2.1 - 22.1 хувиар буурч харин хүүхдийн жинсэн өмд, хатуу чихэр барбарис, гоймон нарийн, эрэгтэй хавар намрын куртик, данх никель, ноосон өмд, хатаасан жимс, байцаа, манжин, төмс, лууван,кетчуп, хөлдөөсөн бууз зэрэг 100 бараа бүтээгдэхүүний үнэ 0.3-71.5 дахин нэмэгдсэн байна.




ХӨДӨӨ АЖ АХУЙ

7 дугаар сарын 1-ний байдлаар оны эхний хээлтэгч малын 73.4 хувь нь буюу 1946.4 мянган эх мал төллөж гарсан төлийн 84.7 хувь нь буюу 1647.7 мянган төл бойжиж байна. Төл бойжилтыг малын төрлөөр үзвэл гарсан ботгоны 96.8

хувь, унаганы 89.9 хувь, тугалын 93.0 хувь хурганы 85.2 хувь, ишигний 79.0 хувь нь бойжиж байна.

Сумдаас Өгийнуур, Төвшрүүлэх, Батцэнгэл, Булган, Чулуут сумд гарсан төлөө 99.2 – 95.5 хувиар бойжуулж байна.




Өнгөрсөн оны мөн үеийнхээс аймгийн дүнгээр төллөсөн эх мал 2.7 хувиар, бойжиж байгаа төлийн тоо 15.2 хувиар бага байгаа бол төлийн хорогдол 5.3 дахин их байна.

Эхний 6 сарын байдлаар оны эхний мал 94.5 хувиар онд орж оны эхний малын 5.5 хувь буюу 341.8 мянган том мал хорогдов. Хорогдсон малын 0.01 хувийг тэмээ, 5.7 хувийг адуу, 7.1 хувийг үхэр, 54.8 хувийг хонь, 32.4 хувийг ямааны хорогдол эзэлж байна.

Сумдаас Хайрхан, Өлзийт, Жаргалант, Цэцэрлэг сумдын оны эхний малын 10.6 – 11.8 хувь нь, Эрдэнэбулган, Батцэнгэл, Өгийнуур, Төвшрүүлэх сумдын оны эхний малын 1.0-1.5 хувь нь хорогдсон байна.

Зүй бусаар хорогдсон малын тоо бүтэц, төрлөөр



Энэ хавар 8319 га-д үр тариа, 251.5 га-д төмс, 128.1 га-д хүнсний ногоо, 2945.79 га-д малын тэжээлийн ургамал, 901 га-д техникийн ургамал тус тус тариалаад байна.

Өнгөрсөн оны энэ үеийнхтэй зэрэгцүүлэхэд үр тариа 8.0 хувиар, төмс 4.8 хувиар буурч харин хүнсний ногоо 1.6 хувиар, техникийн ургамал 38.6 хувиар, тэжээлийн ургамал 2.7 дахин их тариалсан байна.


2020 онд манай аймаг ойгоос 93.6 мянган м³ галын түлээ, 10.6 мянган м³ хэрэгцээний мод, бүгд 104.2 мянган м³ мод авч ашиглахаар баталсанаас оны эхний 7 сард 30.9 мянган м³ галын түлээ, 7.3 мянган м³ хэрэгцээний мод, бүгд 38.2 мянган м³ мод бэлтгэж хэрэглэсэн байна. Бэлтгэсэн модны гоожингийн орлогоор 127.7 сая төгрөг төсвийн орлогод оруулсан байна.



АЖ ҮЙЛДВЭР

Үйлдвэрийн газрууд 2020 оны эхний 7 сард оны үнээр 3971.5 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж 3714.9

сая төгрөгийн бүтээгдэхүүн борлуулсан нь өнгөрсөн оныхоос үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн 1.1 хувиар, борлуулсан бүтээгдэхүүн 1.0 хувиар тус тус өссөн байна. Зэрэгцүүлэх үнээр үнэлснээр 2205.3 сая төгрөгийн нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 5.0 хувиар их байна.



Нийт үйлдвэрлэлтийн 22.4 хувийг хүнс ундааны, 1.3 хувийг хэвлэлийн, 51.3 хувийг дулааны эрчим хүчний, 12.7 хувийг усан хангамж, 2.7 хувийг модон эдлэлийн, 8.1 хувийг гутал хувцасны, 1.5 хувийг бусад үйлдвэрлэл эзэлж байна.

Гол нэрийн бүтээгдэхүүнээс талх, нарийн боов, хэрчсэн гурил, бууз, борц, түгээсэн цэвэр ус, монгол гутал, монгол дээл, гэрийн модон тавилга, хүрмэн блокны үйлдвэрлэл 0.1 – 99.6 хувиар нэмэгдэж, харин савласан цэвэр ус, зүсмэл, хүснэгт маягт, гэрийн мод, вакуум цонхны үйлдвэрлэлийн хэмжээ 1.6 – 70.4 хувиар буурсан байна.

Тээврийн байгууллагууд 28.9 мянган зорчигч, 133.7 мянган тонн ачаа тээвэрлэн 11.7 сая хүн км, 2.7 сая ткм ажил гүйцэтгэн 656.0 сая төгрөгийн орлоготой ажиллаа. Өнгөрсөн

оны мөн үеийнхээс зорчигч, зорчигч эргэлт 22.5-27.8 хувиар буурч, харин тээсэн ачаа 8 дахин өссөн байна.

Холбооны байгууллагууд 1088 телефон цэг улс, хот хоорондын телефон, интернет, телевизийн үйлчилгээгээр байгууллага иргэдэд үйлчилж нийт 5852.1 сая төгрөгийн орлоготой ажилласан нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 1.7 хувиар буурсан байна.



ЦАГ УУРЫН БАЙДАЛ

7 дугаар сард агаарын дундаж температур 14.3-аас 20.7 хэм байсан бөгөөд хамгийн их дулаан Хашаат, Өлзийт, Өгийнуур, Хотонт, Батцэнгэл сумдад 30.0 - 32.0 хэм хүрч байсан бол хамгийн нам хэм нь Өндөрүлаан, Хангай, Тариат, Цэцэрлэг, Хотонт, Булган, Эрдэнэбулган сумдад 2.0-оос 4.0 хэмд хүрч хүйтэрч байсан байна.

Эхний 7 сарын байдлаар Хашаат, Хайрхан, Эрдэнэбулган, Өндөр-Улаан, Цэцэрлэг, Өлзийт, Эрдэнэмандал, Жаргалант сумдад 102.5 – 184.8 мм хур тундас орсон нь хамгийн их тундастай байгаа бол Хангай, Хотонт, Өгийнуур, Булган, Батцэнгэл сумдад 32.3 – 79.8 мм хур тундас орсон нь хамгийн бага байна.

Статистикийн хэлтэс

2020.08.11